



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

Засгийн газрын IV байр, Бага тойруу 3,
Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15160
Утас: 26 04 37, Факс: (976-51) 26 42 30,
Цахим шуудан: info@audit.gov.mn,
Цахим хуудас: www.audit.mn

2025.03.17 № 07/1054
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Мэдээлэл холбооны сүлжээ ХХК-ийн 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй тайлан, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн орлогын дэлгэрэнгүй, мөнгөн гүйлгээг, бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2024 оны 622 дугаар тогтоолын дагуу Бүх нийтийн үйлчилгээний үүргийн сангийн хөрөнгөөр хэрэгжсэн төслийн хүрээнд бий болсон 17 нэрийн 1,213.3 сая төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг бүртгэсэн байна. Мөн Хөгжлийн хөтөч-дэд бүтэц төслийн хүрээнд бий гадна холбооны сувагчлалын 27 нэр төрлийн 1,372.2 сая төгрөгийн балансын үнэ бүхий хөрөнгийг хүлээн авсан байна.

Аудитын гол асуудал

Аудитын гол асуудал гэдэг нь тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн чухал нөлөөтэй хэмээн мэргэжлийн шүүн тунгаалтаар бидний авч үзсэн асуудал байна. Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2023 оны 700 дугаар тогтоолоор баталсан 2024 оны эдийн засгийн үндсэн үзүүлэлт, зорилтот түвшиний төлөвлөгөөнд нийт орлогыг 65,725.4 сая төгрөгөөр, нийт зардлыг 63,923.1 сая төгрөгөөр, 1,321.1 сая төгрөгийн цэвэр ашигтай ажиллахаар тогтоосон байна.

Гүйцэтгэлээр 67,539.4 сая төгрөгийн орлого бүрдүүлж, 65,630.5 сая төгрөгийн зардал гарган, 1,462.1 сая төгрөгийн цэвэр ашигтай ажилласан байна.

Бусад асуудлын хэсэг

Мэдээлэл холбооны сүлжээ ХХК нь Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу 2024 оны жилийн эцсийн санхүүгийн тайлангаа хуулийн хугацаандаа ирүүлж, Төрийн аудитын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.1-д заасны дагуу аудитын байгууллагаас тогтоосон хугацаанд шаардсан мэдээлэл, баримт бичгийг саадгүй гаргаж ирүүлсэн. Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлтэд бусад мэдээлэл хэсэгт тусгасан асуудал нь хамрахгүй болно.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

САНХҮҮ, НИЙЦЛИЙН АУДИТЫН ГАЗРЫН
ЗАХИРАЛ, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  Ц.НАРАНЧИМЭГ

